



**ҮНДЭСНИЙ
БАЯЛГИЙН САН**

“ЧИНГИС ХААН ҮНДЭСНИЙ БАЯЛГИЙН САН” ХХК

**“ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛЬ”-ИЙН ХЭРЭГЖИЛТЭД
ХИЙСЭН ХЯНАЛТЫН ТАЙЛАН
/2025 ОНЫ IV УЛИРАЛ/**

1. Ерөнхий мэдээлэл

“Чингис хаан Үндэсний баялгийн сан” ХХК-ийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан байнгын хяналт хэрэгжүүлэх чиг үүргийн хүрээнд компанийн 2025 оны дөрөвдүгээр улирлын “Шилэн дансны тухай хууль”-ийн хэрэгжилтэд хяналт, үнэлгээ хийж, илэрсэн зөрчил, дутагдлыг тодорхойлов. Энэхүү хяналт нь “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2025 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн А/53 дугаар тушаалаар батлагдсан “Нэгдлийн дотоод хяналт хэрэгжүүлэх жишиг аргачлал”-д нийцүүлэн хэрэгжүүлсэн болно.

2. Хяналтын зорилго

“Шилэн дансны тухай хууль”-ийн хэрэгжилтийг хангах хүрээнд шилэн дансны цахим хуудсанд байршуулсан тайлан, мэдээллийн үнэн зөв, иж бүрэн байдал, хугацаа баримталсан эсэхэд хяналт, үнэлгээ хийж, хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулахад оршино.

3. Хяналтын аргачлал

- “Нэгдлийн дотоод хяналт хэрэгжүүлэх жишиг аргачлал”-ын 3.4 дэх заалтын дагуу үнэлгээ хийх;
- Шилэн дансны цахим хуудсанд байршуулсан мэдээллийг анхан шатны баримт, ажил гүйлгээтэй тулган шалгах;
- “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-д заасан үнэн зөв, иж бүрэн байдал хангагдсан эсэхийг хянах;
- Мэдээллийг хуульд заасан хугацаанд байршуулсан эсэхийг шалгах.

4. Шилэн дансны цахим хуудсанд байршуулсан мэдээллийн хяналт

“Чингис хаан Үндэсний баялгийн сан” ХХК-ийн шилэн дансны цахим хуудсанд байршуулсан тайлан мэдээг анхан шатны баримттай тулган шалгахад 2025 оны 4 дүгээр улиралд 36 тайлан байршуулахаас 16 тайланг хугацаа хоцроож байршуулсан байна.

“Нэгдлийн дотоод хяналт хэрэгжүүлэх жишиг аргачлал”-ын 3.4-т заасны дагуу шилэн дансны хуулийн хэрэгжилтийг 86% гэж үнэллээ.

Хүснэгт 1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, үнэлгээ 2025 оны 4 дүгээр улирал

"Чингис хаан үндэсний баялгийн сан" ХХК			2025.10 сар			2025.11 сар			2025.12 сар			Тайлбар
№	Тайлангийн нэр		Хугацаандаа эсэх	Үнэн зөв, иж бүрэн эсэх	Үнэлгээ	Хугацаандаа эсэх	Үнэн зөв, иж бүрэн эсэх	Үнэлгээ	Хугацаандаа эсэх	Үнэн зөв, иж бүрэн эсэх	Үнэлгээ	
1. Төсөв гүйцэтгэл	1.1	Төрийн өмчийн аж ахуйн нэгж байгууллагын зорилтот түвшин, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан, тайлбарын хамт (Бүтэн жилээр, Хагас жилээр, Улирал бүр, Сар бүр)	Тийм	Тийм	100%	Тийм	Тийм	100%	Тийм	Тийм	100%	Хугацаанд нь мэдээлэл оруулсан.
	1.12	Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ	Үгүй	Тийм	70%	Үгүй	Тийм	70%	Үгүй	Тийм	70%	Мэдээлэл оруулсан
	1.13	Тухайн жилийн зорилтот түвшинд орсон нэмэлт, өөрчлөлт	Тийм	Оруулах мэдээлэл байхгүй	FALSE	Тийм	Оруулах мэдээлэл байхгүй	FALSE	Тийм	Оруулах мэдээлэл байхгүй	FALSE	Оруулах мэдээлэл байхгүй
	1.14	Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ	Үгүй	Тийм	70%	Үгүй	Тийм	70%	Үгүй	Тийм	70%	Мэдээлэл оруулсан
2. Хөрөнгө оруулалт, тендер, худалдан	2.1	Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, концессын зүйлийн жагсаалт	Тийм	Оруулах мэдээлэл байхгүй	FALSE	Тийм	Тийм	100%	Тийм	Тийм	100%	Хугацаанд нь мэдээлэл оруулсан.
	2.4	Худалдан авах ажиллагааны тайлан	Тийм	Оруулах мэдээлэл байхгүй	FALSE	Тийм	Оруулах мэдээлэл байхгүй	FALSE	Үгүй	Тийм	70%	Мэдээлэл оруулсан
	2.5	Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл	Тийм	Оруулах мэдээлэл байхгүй	FALSE	Тийм	Оруулах мэдээлэл байхгүй	FALSE	Тийм	Оруулах мэдээлэл байхгүй	FALSE	Оруулах мэдээлэл байхгүй
	2.6	Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг	Тийм	Оруулах мэдээлэл байхгүй	FALSE	Тийм	Оруулах мэдээлэл байхгүй	FALSE	Тийм	Оруулах мэдээлэл байхгүй	FALSE	Оруулах мэдээлэл байхгүй
3.Бусад	3.3	Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл	Тийм	Оруулах мэдээлэл байхгүй	FALSE	Тийм	Оруулах мэдээлэл байхгүй	FALSE	Тийм	Оруулах мэдээлэл байхгүй	FALSE	Оруулах мэдээлэл байхгүй
	3.4	Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр	Тийм	Оруулах мэдээлэл байхгүй	FALSE	Тийм	Оруулах мэдээлэл байхгүй	FALSE	Тийм	Оруулах мэдээлэл байхгүй	FALSE	Оруулах мэдээлэл байхгүй
	3.5	Тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт	Тийм	Оруулах мэдээлэл байхгүй	FALSE	Тийм	Оруулах мэдээлэл байхгүй	FALSE	Тийм	Оруулах мэдээлэл байхгүй	FALSE	Оруулах мэдээлэл байхгүй
	3.6	Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт	Тийм	Тийм	100%	Тийм	Тийм	100%	Тийм	Тийм	100%	Хугацаанд нь мэдээлэл оруулсан.
	3.7	Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн	Тийм	Оруулах мэдээлэл байхгүй	FALSE	Тийм	Оруулах мэдээлэл байхгүй	FALSE	Тийм	Оруулах мэдээлэл байхгүй	FALSE	Оруулах мэдээлэл байхгүй
	3.8	Их хэмжээнд тооцогдохуйц хэлцэлд гаргасан баталгаа, батлан даалтын мэдээлэл	Тийм	Оруулах мэдээлэл байхгүй	FALSE	Тийм	Оруулах мэдээлэл байхгүй	FALSE	Тийм	Оруулах мэдээлэл байхгүй	FALSE	Оруулах мэдээлэл байхгүй

4.1 Шилэн дансны цахим хуудсанд хуулийн хугацаанд байршуулаагүй тайлан, мэдээлэл

- 2025 оны 4 дүгээр улиралд нийт 23 гүйлгээ байршуулахаас 15 гүйлгээг хуульд заасан 7 хоногийн дотор байршуулж чадаагүй;
- Нийт гүйлгээний 65 хувь нь хугацаа хоцорсон байна (Хүснэгт 2).

Хүснэгт 2. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээний хоцролт

№	Тайлан	Сар	Байршуулсан гүйлгээ	Үүнээс:		Хоцроосон гүйлгээ %
				Хоцроосон	Хугацаандаа	
1	Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ	2025.10	1	1	-	100%
2		2025.11	1	1	-	100%
3		2025.12	1	1	-	100%
4	Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ	2025.10	8	5	3	63%
5		2025.11	5	1	4	20%
6		2025.12	7	6	1	86%
	Нийт		23	15	8	65%

5. Дүгнэлт

2025 оны 4 дүгээр улирлын байдлаар “Шилэн дансны тухай хууль”-ийн хэрэгжилт ерөнхийдөө хангагдсан боловч зарим төрлийн тайлан, мэдээллийг хуульд заасан хугацаанд байршуулж чадаагүй зөрчил илэрсэн байна. Тухайлбал, мөнгөн орлого, зарлагын гүйлгээний мэдээлэл хугацааны сахилга алдагдсан нь анхаарал хандуулах шаардлагатай асуудал гэж үзэв.

6. Санал, зөвлөмж

- “Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ”-г гүйлгээ хийсэн өдрөөс хойш 7 хоногийн дотор оруулж хэвшихэд анхаарч ажиллах;
- Шилэн дансны мэдээлэл байршуулах дотоод хяналт, хариуцлагын тогтолцоог сайжруулах;
- Компанийн 2026 оны бизнес төлөвлөгөөнд дотоод хяналтыг сайжруулах арга хэмжээг төлөвлөсны хүрээнд Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн түвшинг нэмэгдүүлэхээр төлөвлөж байна.